



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 02 сарын 03 өдөр

Дугаар A/12

Батширээт сум

Асран хамгаалагч, харгалзан дэмжигч
тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь заалт, 67 дугаар зүйлийн 67.1.1 дэх заалт, 71 дүгээр зүйлийн 71.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дагвадорж овогтой Батжаргал нь 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр хүнд өвчний улмаас нас барж түүний охин Батжаргалын Билэгжаргал нь бүтэн өнчин болсон тул Б.Билэгжаргалын асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр Б.Билэгжаргалын төрсөн эгч Батжаргалын Болоржаргалыг тогтоосугай.

2. Холбогдох бичиг баримтын бүрдэл, хувийн хэргийг хөтлөн ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан (Д.Нямсүрэн)-д даалгасугай.

3. Гэр бүлийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийг баримталж Б.Билэгжаргалыг асран хамгаалж, харгалзан дэмжихийг (Б.Болоржаргал)-д даалгасугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Онон багийн засаг дарга (Д.Хонгорзул), Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан (Д.Нямсүрэн) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  БАЛТАНГЭРЭЛ



232601023